



ᠮᠣᠩᠭᠣᠯ ᠤᠯᠤᠰ
 ᠭᠣᠪᠢ-ᠠᠯᠲᠠᠢ ᠠᠶᠢᠮᠭᠢᠨ
 ᠵᠠᠰᠠᠭ ᠳᠠᠷᠭᠢᠨ
 ᠵᠠᠬᠢᠷᠠᠮᠵᠢ

**МОНГОЛ УЛС
 ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
 ЗАСАГ ДАРГЫН
 ЗАХИРАМЖ**

2023 оны 05 сарын 05 өдөр

Дугаар A/274

Алтай хот

Хөрөнгө гаргах тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 66 дугаар зүйлийн 66.1 дэх хэсэг, аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын 2023 оны 03 дугаар сарын 24-ний өдрийн 14 дүгээр тогтоол, аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн 2023 оны 05 дугаар сарын 04-ний өдрийн 21 дүгээр хурлын шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Сумдын Засаг дарга нарын Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Өвөр Монголын Өөртөө Засах Орны Хөх хот, Баяннуур аймгийн мал аж ахуйн гаралтай түүхий эдийг боловсруулж буй үйлдвэрүүдтэй танилцах, туршлага судлах арга хэмжээнд зарцуулагдах зардлыг хавсралтаар баталсугай.

2.Шаардагдах 24,985,000 (хорин дөрвөн сая есөн зуун наян таван мянга) төгрөгийг Орон нутгийн хөгжлийн сангийн "Алсын хараа-2050", "Шинэ сэргэлт"-ийн бодлогын аж үйлдвэржилт болон хот хөдөөгийн сэргэлтийн бодлогын хэрэгжилтэд зарцуулах эх үүсвэрээс санхүүжүүлэхийг Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-д зөвшөөрсүгэй.

3.Тус арга хэмжээг зохион байгуулах удирдамж, хөтөлбөрийг баталж, хэрэгжилтийг ханган ажиллахыг аймгийн Засаг даргын орлогч (Г.Чинбат)-д үүрэг болгосугай.

4.Айлчлалын үр дүнг илтгэх хуудсаар аймгийн Засаг даргын Удирдлагын зөвлөлийн хуралд танилцуулахыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (С.Мөнхжаргал)-т, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Хяналт-шинжилгээ, үнэлгээний хэлтэс (Л.Хаш-Эрдэнэ)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

О.АМГАЛАНБААТАР

Аймгийн Засаг даргын 20... оны
... дугаар сарын ...-ны өдрийн ... дугаар
захирамжийн хавсралт

ЗАРДЛЫН ТООЦОО

| № | Чиглэл | Нэгж үнэ | Хэмжих нэгж | Дүн |
|----------|--|----------|-------------|------------|
| 1 | Улаанбаатар-Замын Үүд-Улаанбаатар (Галт тэргээр-купе-2 талдаа) | 119400 | 20 хүн | 2,388,000 |
| 2 | Боомт нэвтрэлт-ирэх буцах (2 талдаа) | 100000 | 20 хүн | 2,000,000 |
| 3 | Автобусны түрээс | 3432894 | 6 хоног | 20597000 |
| Нийт дүн | | | | 24,985,000 |

__оОо__